https://doi.org/10.69561/mjac.v25i49.3845 **Article | Fasc.20**

Уртын дууны сургалтын хөтөлбөрийн нэгэн хувилбар

Мягмарсүрэнгийн Дорждагва
Монголын үндэсний их сургуулийн Урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ dorjdagvaud@gmail.com

Хураангуй: Уртын дууны хадгалалт, хамгаалалт, өвлөн уламжлах үйл явц болон түүний оршиж ирсэн, цаашид хэрхэн оршин байх тухайд гүйцэтгэсэн олон жилийн судалгаа, мэдлэг-туршлагадаа үндэслэн тус өгүүллийг бичив. “Уртын дууг өвлөн уламжлах замаар үзэл санаа, утга агуулгад нь хадгалагдсан олон зуун жилийн түүхэн ой санамж, ухамсрын болон бие мах бодийн туршлагаас ямар арга замаар авч үлдэх вэ?, монгол уртын дууны урлаг XXI зууны эхэнд ямар чиглэлтэй болох вэ?, өнгөрсөн олон зууны түүхэн дүрүүдээсээ юугаар ялгарах вэ?, юуг нь гээж, юуг нь өвлөх вэ? гэсэн асуултууд дэвшүүлэн ажиллав. Асуултынхаа хариултыг хайх үндсэн талбараар нь бие даасан сургалтын хөтөлбөр зохион хэрэгжүүлэх туршилт судалгаа гүйцэтгэв. Ингэснээр “Бие даасан сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилт, үр дүн нь XXI зууны уртын дууг тодорхойлно” гэсэн гаргалгаанд хүрэв.

Түлхүүр үгс: *уламжлал, орчин үе, мэдлэг, ур чадвар, хандлага*

A variant of the long song training curriculum

Dorjdagva Myagmarsuren
School of Arts, Mongolian National University, Ulaanbaatar, Mongolia
✉ dorjdagvaud@gmail.com

Abstract: The article is written based on many years of study, research and experience regarding the preservation, protection, and inheritance of long songs, as well as its continuity and vision in the future. The questions of “What are the most potential methods to preserve centuries-old historical memory, conscientious, and physical experiences preserved in the idealogy and meanings of the long-songs by passing down long songs? What will be the approaches and tendencies of Mongolian vocal art of Urtyn-Duu (Long-song) in the 21st century? What will be the distinct features and characteristics to distinguish from the historical figures of the past centuries? What will be lost and what will be inherited?” were taken into consideration. A pilot study was conducted to develop and implement an independent training curriculum as the main platform and field of searching for the answer to the questions. As a result, the study led to a issue that “An independent curriculum, its implementation, and results will determine the long-song of the 21st century”.

Received: 2024.08.07/ Accepted: 2024.12.02
© Author (s). 2024

Keywords: *tradition, modern, knowledge, proficiency, approach*

Оршил

Эл судалгаагаар орчин үеийн "уртын дуу"[1]-нд суралцагчдын нийтлэг ба хувийн онцлогийг харгалзсан суралцагч төвтэй сургалтын хөтөлбөрийн нэгэн хувилбарт хүрэх зорилготой ажиллав. Суралцагчдын дуулах мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэх онол, практикийн үндэслэл бүхий нэгэн баримт бичиг бүрэлдүүлэх нь тус судалгааны зорилт болсон билээ. Тиймээс орчин үеийн боловсрол судлалын сургалтын хөтөлбөрийн чиг хандлага ба салбар мэргэжлийн онцлогийг уялдуулсан уртын дууны урлагийн бие даасан хөтөлбөрийн нэгэн хувилбарт хүрнэ гэх таамаглал дэвшүүлсэн юм. Улмаар уртын дууны урлагийн уламжлалт зүй тогтлыг орчин үеийн олон ургалч үзэл болон дэвшилтэт техник технологитой хослуулах замаар суралцагчдад чиглэсэн шинэлэг мэдлэг, чадвар, хандлага дагуулсан загвар зохион хэлэлцүүлэхийг хичээв.

Судалгааны арга зүй

Тус хувилбарыг 2008-2024 оны хугацаанд гүйцэтгэсэн судалгаа болон албан ба албан бус сургалтын мэдлэг, туршлагадаа үндэслэв. Түүнчлэн, "2014-2018 онд герман 1, итали 1, франц 1, швейцар 1, япон 1, хятад 1 хүнийг тус тус хамруулан 14-45 хоногийн албан бус агуулгын сургалт зохиосон" (Дорждагва 2022, 100). Хоёрдугаар үе шатыг дотоодын албан бус сургалтын хүрээнд 2023 оны 06-р сараас эхлэн хэрэгжүүлж буй бол 2023 оны 09-р сараас их сургуулийн орчинд сургалт явуулж байна. Ингэхдээ Улаанбаатар хотод төвлөн ажилласан. "Конструктивизм" (Жилээ, Тамир, Дэлгэржав 2020, 35)-ийн онолыг баримтлах замаар задлах, нэгтгэх, жишээ татах, тайлан тайлбарлах болон туршилтаар салбарын хүрээнд нэвтрүүлж буй албан ёсны эрхтэй дуут дүрс (Spectrogram)[2]-ийн аргыг ашиглав.

---

1 Монголын нэн эртний бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн нийгэм-соёлоос гаралтай: 1/ Байгалиас үүдсэн, байгальтай холбоотой, байгалийн зүй тогтлоор үүссэн, 2/ Байгальд халгүй, байгальд ээлтэй, эрүүл байгальлиг, суурь язгуур чанартай, 3/ Байгалийн жам ёсны зүй тогтлоороо, байгалийн төрөлх, байгаль дахь бүрдвэр өгөгдлийг агуулсан, 4/ Байгалийн төлөөлөл болохуйц язгуур байдлаа хадгалах замаар бие даасан урлагийн төрлийг *"Уртын дуу-UrtynDuu"* гэнэ (М.Дорждагва).

2 Acoustica 7_4_us_427418102c, 2022: Спектрограммыг дуу хөгжим, хэл шинжлэл, дууны аппарат, радар долгион, ярианы боловсруулалт, газар хөдлөлт судлал болон бусад салбарт өргөнөөр ашигладаг.



Зураг 1. *Дуут дүрсийн арга*

Судалгааны үр дүн

Уртын дууны урлагийг бие даасан хэлбэрээр, албан ба албан бус сургалтаар уламжлах зорилго бүхий эл хөтөлбөр нь XXI зууны салбарын сургалтад шинэлэг үзэл санаа, арга зам, гаргалгаа эрэн хайсан нэгэн оролдлого болж байна. Тус хөтөлбөр нь бидний сургалтын зарим орон зайг нөхөж буйгаараа онцлогтой байж болох талтай. Орчин үеийн боловсрол судлалын онол, арга зүй, хөтөлбөрийн бүтцийг уртын дууны урлагтай уялдуулах явцад багагүй бэрхшээлтэй тулгарсан. Өөрөөр хэлбэл, манай уртын дууны сургалтад семинар зонхилдог юм. Уртын дууны урлагийн суурь мэдлэгийг хөгжүүлэх онол, арга зүйн лекц хичээл нэн ховор билээ. Салбарын нэгэн судлаачийн хувьд суралцагчдын дуу хоолойн хөгжлийн явцыг хэмжих шинжлэх ухааны бодит тооцоолол бүхий арга ололгүй нэлээд цаг хугацаа алдсан тул энэ дашрамд хүлцэл өчье. Тиймээс сүүлийн үед уртын дууны сургалтад аль болох шинэлэг технологи туршихыг хичээсээр байна. Улмаар эл судалгааны арга зүйн нэгэн үр дүн нь дараах туршилтаас мэдэгдэв. Үүнд:

Хүснэгт 1. *Хөтөлбөрийн туршилтын тэмдэглэл*

Хугацаа: 2023 оны 09 сарын 01-ээс 12-р сарын 26			
Сэдэв	**Туршилт эхлэхийн өмнөх үе**	**Туршилтын дараах үе**	**Дутагдал болон цаашид хэрэгжүүлэх зүйл**
“Сэрүүн сайхан хангай” айзам уртын дуу	1/ Өөртөө итгэх итгэл багассан. Жишээ нь, уг сэдэвт дууг санал болгоход “чадахгүй байх” гэж эргэлзсэн. 2/ Суралцагчийн хоолойн өвөрмөц байдлыг харгалцаагүй. 3/ Сэтгэл зүйн онцлогийг нь харгалзаагүй. 4/ Ганцхан “уухай” дасгалаар хоёр жил хөгжүүлэх гэж оролдсон	Өөртөө итгэх итгэл нэмэгдсэн. Өөрийн хүсэлтээр томоохон бүтэц, агуулгатай айзам, шастир уртын дуунаас сонгон багшид зөвшөөрөхийг санал болгож эхэлсэн. Өгүүлэхүйн эрхтний боломж нөөцөө бусдаас өөр болохыг таньсан. Багшийн олон талт дасгалуудыг эзэмшсэн. Утга учрыг нь тайлан тайлбарлахыг хичээж “Ум” дасгалын сэтгэл зүйн үр нөлөө” сэдвээр “Сэтгэл зүй”-н хичээлийнхээ бие даалтыг гүйцэтгэж, амжилттай хамгаалсан.	Туршилтын үед “Ум”, “Хэлбүүр”, “Давхилт”, “Хурай” дасгалуудыг түлхүү өгч, өөрийг нь тавгүйцүүлдэг “уухай” дасгалыг бага өгсөн. Ингэснээр тойрог хоорондын амьсгаа авах зай хол буюу нууц амьсгаа авах хугацаа бараг 1 секунд хүрч удаан хэвээрээ байна. Үүнийг “Уухай” дасгалыг дээрх дасгалуудтай тэнцвэржүүлэх замаар засах үйлийг үргэлжлүүлэн тусгай дасгалуудыг зохиож хэрэглэх шаардлагатай.
Тус суралцагчийн онцлогт тохируулсан тусгай дасгалын арга			
1/ Гуравц, дөрөвц, тавцын зайд “Давхиулах” дасгал, **2/** “Хурай” дасгалыг үггүй хувилбараар эгшиг залган нууц амьсгаа, түүний холболтыг хөгжүүлэх арга хэрэглэсэн. Уг арга нааштай үр дүн үзүүлэх төлөвтэй нь мэдэгдэв. Тодруулбал, нууц амьсгаа авах тэр агшны хугацаа багасаж, тогтвортой өргийн тэгшхэн дуугаралт нэмэгдэн, цэвэрхэн тод, ашигтай болж ирэв. Өөртөө итгэх итгэл нь улам нэмэгдэв.			

Зураг 2. *Анологи долгион (загварчлал)*



Зураг 3. *Дуут дүрсийн задлал*



***Зураг 4**. Дуут дүрсийн өгөгдөл дэх ашигтай хөгжиж эхэлсэн эсүүд*

Эрчимтэй хөгжиж буй нь давхар шуранхайлах (**4.**) эв дүй мөн гэж үзэж болно. Энэ нь боржгин халх дүрсийн давхар шуранхай юм. Дууны аялгууны оргил хэсэгт тохиолдож буй уг дүрсээс цоройх[3], буух, давхих, хатгах, эгшиг шүүрэх, шавхахаас бүтдэг уламжлалт үзүүлэлтүүд нь цэгцтэй бөгөөд ашигтай илэрчээ.



***Зураг 5.** Дуут дүрсийн давтамж (герц-Hz)-ийн үзүүлэлт*

Дундаж давтамж (Hz) нь 736.9 буюу эдгэрэлтийн давтамжид хүрсэн гэж үзэж болно. Энэхүү тооны утга нь:

- Орчлон ертөнцийн хязгааргүй элбэг дэлбэг байдал,
- Гүн бясалгал,
- Унтах, амрах зэргээр хэрэглэгч сонсогчид нөлөөлөх увдис бүхий давтамжийг тус оюутан энэхүү туршилт сургалтын үр дүнгээр олжээ.

Дээрх үр дүн тус суралцагчийн сэтгэлийн мөн чанар, дуу хоолойн байгалиас өгөгдсөн боломжтой холбоотой байж болох талтай. Цаашид гуравц, дөрөвц, тавцын зайн давхилт дээр нэмэн бага долооцын давхилт, хос эгшгийн дуудлага зэргийг сайжруулах шаардлагатай. Үүнийг хоолойн дасгалын аргаар шийдвэрлэх боломжтой.

[3] Дуучны хоолойн туулах зам буюу ур эгшгийн хүчдэл (dB)-ээр өгсүүлсэн дөрөвц (кварт), тавц (квинт)-ийн зай (интервал)-н дуугаралт.

Хэлэлцүүлэг

1/ Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ[4]: Сүүлийн жилүүдэд уртын дуунд суралцах сонирхол бүхий иргэд нэмэгдэв. Өөрөөр хэлбэл, 1940-өөд оноос хойш нийгэм-соёлын талаасаа уртын дууны хэрэглээ өргөжих шинж түгээмэл ажиглагдав. Жишээ нь, уртын дууны судалгаа, сургалтын "Айзам" төв[5]-ийн албан бус сургалтад 2023-2024 оны байдлаар нийт 42 хүн хамрагдаж буй бөгөөд тэд дунджаар 12-75 насныхан юм. Эдгээр суралцагчдад уртын дууны ямар хэрэгцээ, зорилго буйг сургалтад оролцсон эхний өдөр нь ярилцаж, аман асуулгын аргаар тодруулан тэмдэглэж авдаг[6]. Үүнд:

Нэгдүгээрт: Мэргэжлийн 9 уртын дуучин тус албан бус агуулгын сургалтад хамрагджээ. Тэд өмнө нь олсон дуулах мэдлэг, ур чадвараа шинэ мэдлэг, чадвар, хандлагаар баяжуулах замаар уран бүтээлийн чанараа сайжруулах зорилготой юм.

Хоёрдугаарт: Сонирхогч суралцагчдаас дараах таван хэрэгцээ мэдэгдэв. Үүнд:

- Найрын гурван дуутай болох зорилготой хүн 10 /эрэгтэйчүүд зонхилдог/,
- Өөрийн өвөг дээдсийн уртын дуунаас өвлөн уламжлах хүн 5,
- Хүүхэд ахуйдаа аав ээж, өвөө эмээгээсээ болон нутгийнхаа найр наадмын орчинд сонсон дуурайж байгаад мартсан, түүнийгээ сэргээн санах 5,
- Бясалган дуулж, сэтгэлийн амар амгаланг хүртэх 7 /эмэгтэйчүүд зонхилдог/,
- Гадаадад хол амьдарч буй нутгаа санасан аав, ээж, эмээ, өвөө зэрэг хайртай хүмүүсийнхээ хүсэлтийн дагуу уртын дуу сурах зорилготой ирсэн 6 хүн байна.



Зураг 6. *Уртын дуунд суралцах хэрэгцээний харьцуулалт, 2024 оны байдлаар*

Арга зүй хэсэгт дурдсан гадаадын 6 хүнээс дараах зорилгууд мэдэгдсэн:

- Уртын дуунд суралцах замаар байгалийн сэрэл/хүртэхүйгээ олж авах, зарим нь дахин сэргээх /францийн Стив Морел, швейцарын Элизабет/,
- Уртын дууг өөрөө дуулж сурах замаар эрдмийн зэрэг хамгаалах /германы Сабрина Маргарита Зауэр/,
- Уртын дуу дуулах мэдлэг, ур чадварт суралцах замаар өөрийн дууны уран бүтээлийн төрлийг баяжуулах /италийн Карлотта Жовино/,
- Өөрийн нэр хүндийг өсгөн, шууд замаар эдийн засгийн үр ашгаа нэмэгдүүлэх /ази хүмүүс зонхилдог /японы Мацукова, хятадын Чэн Ли//

4 Хөтөлбөрийн туршилт судалгаанд нийт 53 хүнийг хамруулсан.
5 Гэрчилгээ: № 000325833
6 "Багшийн ажлын дэвтэр" (тэмдэглэл хөтөлсөн багш М.Дорждагва, 2023-2024)

МҮИС-ийн Урлагийн сургуульд 2023-2024 онд суралцаж буй 5 оюутан:

- Хэн нэгэн алдартай дуучны адил мэргэжлийн сайн уртын дуучин болох,
- Аав ээж, эмээ өвөө зэрэг хүмүүсийн удам залгасан дуучин болох,
- Сайн дуучин болж ураг удам, нутаг усныхаа нэрийг өндөрт өргөх,
- Уртын дуу дуулах өвөрмөц чадвартаа түшиглэн бусад төрлийн дууны уран бүтээл туурвих зэрэг олон агуулгат зорилготой байна.

Дурдсан хэрэгцээ, зорилгуудыг биелүүлэхэд эл хөтөлбөр бодит дэмжлэг үзүүлэх замаар суралцагчдын уртын дууны онолын суурь мэдлэг болон дуулах ур чадвар, эерэг хандлагыг төлөвшүүлнэ.

2/ Зорилтот бүлэг: Албан сургалтаар I-IV курсийн суралцагч тус бүрийн хувийн онцлогт суурилан уртын дуунд суралцахуйд сургана. Албан бус сургалтаар хувь хүн, хүмүүс, бүлэг, хамт олны арьс өнгө, нас, хүйс, шашин шүтлэгийг үл харгалзан тэгш хүртээмжтэй үйлчилнэ.

3/ Зорилго, зорилт (РЕО)*: Монгол уртын дууг дотоодын болон олон улсын түвшинд өвлөн уламжлах, дуулан сурталчилж, түгээн дэлгэрүүлэх арга ухаанаа насан туршдаа хөгжүүлэх хэмжээнд төлөвшсөн, XXI зууны уртын дууны олон талт мэдлэг, чадвар, хандлага бүхий хүнлэг энэрэнгүй, эрүү саруул уртын дуучныг тус хөтөлбөрийн үйлээр бэлтгэн нийгэм-соёлын оролцоо руу шилжүүлнэ.

4/ Бүтэц: Лекц, семинар, бие даалт

5/ Хөтөлбөрийн агуулга:

Хүснэгт 2. *Мэргэжлийн лекц хичээлийн агуулга*

Мэргэжлийн лекц хичээл		
Мэдлэг	**Чадвар**	**Хандлага**
Уртын дууны үүсэл хөгжил	Уртын дууны мөн чанарыг хадгалан дуулах чадвар	Уртын дууны түүхийн ойлголт бүрэлдэнэ.
Уртын дуу дуулах зан үйл	Аливаа орчин, нөхцөлд хөрвөн дуулах чадвар	Аливаа зан үйлд үйлчлэхдээ дууны зөв сонголт хийж сурна.
Уртын дуучны орон зайт сэтгэлгээ	Байгалийг харах, сонсох, үнэрлэх, хүртэх, амтлах чадвар	Хязгаарлагдмал орчны нөлөөлөлд автахгүйгээр дуулж сурна.
Дуу авиа үүсэх механизмын онол	Дуулах үеийн бие махбодын үйл ажиллагаагаа хянах чадвар	Дуулалтын алдаа дутагдлаа хүлээн зөвшөөрч сурна.
Гурван тулгуурт онол	Дуулах ур чадварын уламжлалт учир зүйг ашиглах чадвар	Дуугаа тархи оюундаа зөв боловсруулан зөв илэрхийлнэ.
Тойргийн онол	Уртын дууны аялгуу дахь тойролтын чадвар	Тойргийн онолын зарчмыг баримтлан дуулж сурна.
Бүтцийн онол	Үндсэн ба бичил хэмнэлийн чадвар	Уртын дууны бүтцийг өөрчлөхгүй сурч дуулна.
Хүчдэлийн онол	Эрүүл мэндийн сөрөг үр дагаваргүйгээр дуулах чадвар	Тэсвэр хатуужилд сурна.
Хувилбарын онол	Олон хувилбарыг ялган таних чадвар	Олон хувилбарыг дуулж сурна.

Уртын дууны тархалт, өв сан	Урын сангаа баяжуулах чадвар	Олон шугамт хэвтээ тэнхлэгийг ашиглаж сурна.
Уран, гоо сайхан ба дүр бүтээх үйл	Байгаль, нийгмийн дүрийг илэрхийлэх чадвар	Уран сэтгэмжтэй дуулж сурна.
Чуулга дуулалт, түүний уламжлал	Гинжин амьсгаа, гинжин аялгууг туурвих чадвар	Багаар ажиллаж сурна.
Дуучны ёс суртахуун	Дуучны биеэ зөв авч явах чадвар	Соёлтой дуучин болно.
Хөгжмийн онол	Хөгжмийг ШУ-ыг ашиглах чадвар	Ашигтай дуугаралт, дуулалттай болно.
Хөгжмийн сонсол зүй	Хөгжмийн эгшиг бичих, унших чадвар	Уртын дууг эгшиг бичигт буулган ашиглаж сурна.
Хөгжмийн зохирол	Найруулгыг ойлгох чадвар	Хөгжимлөг дуулалттай болно.
Монголын хөгжмийн түүх	Монгол хөгжмийг таних, тайлбарлах чадвар	Уртын дуундаа ул суурьтай хадаж сурна.
Хэл ярианы техник	Авиа зүйн чадвар	Тод хэллэгтэй болно.
Хоолойн эрүүл ахуй	Хоолойгоо арчлан гамнах чадвар	Уур амьсгалд дасан зохицох, хоол хүнсний зөв дадалтай болно.
Тайзны тавил	Тайзны соёл, тоглолтын чадвар	Уран бүтээлийн практик сууна.
Төгөлдөр хуур тоглох ур зүй	Дуугаа сурах, илэрхийлэх нэг төрлийн чухал чадвар	Дуулалт, дуугаралт улам тодорхой болно.
Гадаад хэл	Судлах, бүтээн туурвих, тоглох нэг төрлийн чухал чадвар	Уран бүтээлийн цаг хүрээгээ өргөжүүлж сурна.
Дэлхийн урлагийн түүх	Хүн төрөлхтний урлагийн төрлүүдийг таних чадвар	Уран бүтээлдээ урлагийн бусад төрлөөс ашиглаж сурна.
Дэлхийн хөгжмийн түүх	Хүн төрөлхтний олон төрөл дуу, хөгжмийг ялган таних чадвар	Олон хэв шинжээр уран бүтээлээ туурвиж сурна.
Ази, Дорно дахины хөгжмийн түүх	Бүс нутгийн хөгжмийн урлагийг таних, тайлбарлах чадвар	Уран бүтээлээ олон талт хэлбэрээр хөгжүүлж сурна.
Урлагийн философи	Урлагт буй ой санамжийг таних, ашиглах чадвар	Дуучны амьдрах ухаанд төлөвших
Сэтгэл зүй	Сэтгэл санаагаа удирдах чадвар	Дуучны сэтгэл зүйг төлөвшүүлнэ.
Судалгааны арга зүй	Судалгаа хийх чадвар	Уртын дууг судлан сурч төлөвшинө.
Хууль, эрх зүй	Хуулийг ашиглах чадвар	Зохиогчийн эрхийг хүндлэх соёл төлөвшинө.
Соёлын менежментийн онол, арга зүй...	Уран бүтээлээ төлөвлөх чадвар	Уран бүтээлийн төсөв, цаг хугацаа, орон зайн эрсдэлээс өөрийгөө хамгаалж сурна.

6/ Хөтөлбөрийн арга зүй:

Ерөнхий арга:

- Сэдэлжүүлэх
- Ажиглах (Байгалмаа 2013, 77)
- Тэмдэглэх
- Асуух
- Ярилцах
- Дуу, дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулах
- Дуут дүрс (Spectrogram)-ийн хэмжилт хийх
- Тайлан тайлбарлах
- Багш өөрийн биеэр туршин дуугарч үлгэрлэх
- Суралцагч өөрийн онцлогт суурилан турших

Компьютер томографын аргаар суралцагч өөрийн дуу хоолойгоо танин мэдэх

Жишээ сонсгох, үзүүлэх /суралцагчийн дүгнэлтийг хийлгэх ба халуун сандалд суулгах/

- Хосоор болон багаар ажиллах зэрэг ерөнхий арга болно (Хоолойн дасгал ажлын танин мэдэхүйн алхмуудыг **Хавсралт**аас үзнэ үү).

Мэргэжлийн ганцаарчилсан тусгай семинарын арга:

- **Ажиглах:** Хичээлд бэлэн эсэхийг нь таних арга
- **Умлах:** Анхаарлыг нь төвлөрүүлэн дуу хоолойг сэрээж, хамрын хөндий, цээжний хөндийн цуурайлга, урт эгшиг болон бага гуравц, их хоёртын зайг цэвэрхэн гүйцэтгэх, амьсгал зөв авах эв дүй[7] суулгах арга
- **Хэлбүүрдэх:** Хоолойн царааг тавц, дөрөвц, их хоёртын зайн дуугаралт-шилжилтээр тэлэн эгшиглэлийг тэгшхэн гаргах эв дүй суулгах арга
- **Хурайлах:** Урт эгшгийг дангаар нь тогтвортой, ашигтай гүйцэтгэх, амьсгаагаа жигд тэгшхэн гаргах эв дүйг хөгжүүлэх арга
- **Шуранхайлах** (Дорждагва 2018, 351)**:** Нам, дан, давхар шуранхайг хөгжүүлэх арга
- **Уухайлах**[8]**:** Ерөнхий дуулалтыг хөгжүүлэх арга
- **Давхиулах** (Жанцанноров 2005, 25)**:** Таван эгшигтийн түгээмэл эгнээг хадгалан хоолойн дуугаралтыг журамлах замаар наймцын зай үүсгэн давтамж (Hz), хүчдэл (dB) ба гулсалтыг хөгжүүлэх арга
- **Нийлэх:** Морин хуур хөгжимтэй хамсран дуулах эв дүйг хөгжүүлэх арга

Мэргэжлийн тусгай семинараар өгөх сэдэвт дууны төрөл, ангилал:

- Айзам дуу (угсаатны бүлэг, овгийн)
- Шастир дуу (угсаатны бүлэг, овгийн)
- Гүр дуу (угсаатны бүлэг, овгийн)
- Морин дэлийн дуу (угсаатны бүлэг, овгийн)
- Тайзны буюу мэргэжлийн дуу (айзам, суман, бэсрэг ангиллаар)

7 Авьяас, мэдрэмжийг нээх, хөгжүүлэх гэсэн санаа

8 Н.Норовбанзадын зохиож хэрэглээнд оруулсан түгээмэл дасгал

Албан сургалтаар суралцагчийн ур чадварыг дуугаар хөгжүүлэх шатлал:

- I курс. Боржигин халх зонхилсон уртын дууны дижитал сангаас сонголт өгөх /нийт 12 дууг судлан сурна/.
- II курс: Тайзны хэлбэрийн хувьд бэсрэг, болон суман ба угсаатны бүлэг, овгийн дууны дижитал сангаас сонголт өгөх /нийт 12 дууг судлан сурна/.
- III курс: Угсаатны бүлэг, овгийн болон тайзны "Айзам" хэлбэрээс сонголт өгч эхэлнэ. Нийт 12 дуу судлан сурна. Уламжлалт чуулга дуулалтад суралцана. Практик дадлагад гарна.
- IV курс 1. Угсаатны бүлэг, овгийн болон тайзны айзам, суман хэлбэрээс нийт 3 дууг бүрэн эхээр нь судалж сурна. 2. Практик дадлагад гарна. 3. Мэргэжлийн ур чадварын эцсийн шалгалтад бэлтгэн шалгалт өгнө. 4. Мэргэжлийн судалгаа гүйцэтгэн хамгаална. 5. Тайлан тоглолтод бэлтгэн тайлагнана.

7/ Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Зураг /хөдөлгөөнт ба уламжлалт/
- Диаграмм
- График
- Схем
- Интеракив /дүрс бичлэг, аудио бичлэг/
- Хэвлэл /дотоод, гадаадын мэргэжлийн ном, сэтгүүл, гарын авлага, сурах бичиг/
- Интернэт /мэргэжлийн судалгааны цахим үүрүүд/
- Хөгжмийн зэмсэг /төгөлдөр хуур, морин хуур, лимбэ хөгжим/
- Цахим программ /Acoustica, MuseScore/
- Бусад төхөөрөмж /Decibel meter, Raspberry-дуулах үеийн хоолойн чанга сул ба зүрхний хэмийг хэмжих багаж, Voice recorder, Компьютер Томограф гэх мэт/

8/ Сургалтын хэлбэр: Танхимаар 90%, онлайнаар 8%, байгалийн буюу хээрийн уран сайхны сургалтаар 2% нь хэрэгжинэ. Хөтөлбөрийн сургалтыг стандарт болон агуулгын гэх хоёр хэлбэрээр урт, богино хугацаанд хөрвүүлэн, уян хатан, нээлттэйгээр ашиглана.

9/ Үнэлгээ (Ичинхорлоо 2013,19)**:** Лекцийн мэдлэгийг бие даалт болон дипломын бичвэрээр, мэргэжлийн ганцаарчилсан дуулах тусгай семинарын үр дүнг тайзны орчинд дуулах ур зүйн явцын болон эцсийн шалгалтаар үнэлнэ (Үнэлгээний хуудас 1, 2-ыг **Хавсралт**аас үзнэ үү).

10/ Сэдэвчилсэн төлөвлөгөө:

Хүснэгт 3. *Мэргэжлийн суурь хичээлийн хөтөлбөр-**CLO** (бичил загвар)*

Хугацаа:					
№	**Гараг**	**Цаг**	**Хичээлийн сэдэв**	**Цаг**	**Багшийн нэр**
1	Лхагва	09:10-10:40	Монгол уртын дууны үүсэл хөгжил, дуулах зан үйл	16	.....
2	Даваа	09:10-10:40	Уртын дууны онолын ойллого	16	
3	Мягмар	09:10-10:40	Уртын дууны тархалт, ангилал, төрөл зүйл	16	
4	Пүрэв	09:00-10:40	Уртын дууны уран сайхны дүр бүтээх арга, үйл явц	16	
5	Даваа	10:50-11:20	Чуулга дуулалтын арга, туршилт	16	
6	Баасан	10:50-11:20	Уртын дуучны уламжлалт ёс суртахуун ба орчин үе	16	
7	Даваа, Лхагва, Баасан	13:10-16:20	Дуулах ур зүй *(ганцаарчилсан тусгай семинар)*	47	
8	Даваа	16:30-18:00	Чуулга дуулалт /хамтын семинар/	16	
9	Баасан	13:10-16:20	Хээрийн дадлага	1	
				160	

Хүснэгт 4. *Үндсэн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө (албан сургалт)*

Мэргэжил: Уртын дууны урлаг				Суралцах хугацаа: 4 жил	
Мэргэжлийн индекс: ...				Нийт багц цаг: 113	
Боловсролын зэрэг: Бакалавр				Элсэгчийн болзол: Дээд	
Д/Д	**Индекс**		**Хичээлийн нэр**	**Багц цаг**	**Улирал**
А1. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ (ЗААВАЛ СУДЛАХ)				30	
1	1	...	Монгол уртын дууны үүсэл хөгжил, дуулах зан үйл	3	I, II
2	2	...	Уртын дууны онолын ойллого	3	I, II
3	3	...	Уртын дууны тархалт, ангилал, төрөл зүйл	3	I, II
4	4	...	Уртын дууны уран сайхны дүр бүтээх арга, үйл явц	3	I, II
5	5	...	Чуулга дуулалтын арга, туршилт	2	I
6	6	...	Уртын дуучны уламжлалт ёс суртахуун ба орчин үе	3	I, II
7	7	...	Монголын хөгжмийн түүх	4	I-IV
8	8	...	Дэлхийн хөгжмийн түүх	3	III, IV
9	9	...	Ази, Дорно дахины хөгжмийн түүх	3	II-III
10	10	...	Урлагийн философи	3	III, IV
А2. МЭРГЭЖЛИЙН ТУСГАЙ СЕМИНАР (ЗААВАЛ СУДЛАХ)				39	
11	1	...	Дуулах ур зүй	36	I-IV
12	2	...	Чуулга дуулалт	2	I-II
13	3	...	Хээрийн дадлага	1	II, IV
Б1. МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛ (ЗААВАЛ СУДЛАХ)				36	
14	1	...	Хөгжмийн онол	3	I, II

15	2	...	Хөгжмийн сонсол зүй	4	I-IV
16	3	...	Хөгжмийн зохирол	3	IV
17	4	...	Монголын хөгжмийн түүх	3	IV
18	5	...	Хэл ярианы техник	4	I-IV
19		...	Хоолойн эрүүл ахуй	2	
20	6	...	Тайзны тавил	3	I-IV
21	7	...	Төгөлдөр хуур тоглох ур дүй	4	I-IV
22	8	...	Сэтгэл зүй	3	I, II
23	9	...	Судалгааны арга зүй	3	III, IV
24	10	...	Англи хэл	3	I, II
25	11	...	Дадлага ажил (мэргэжлийн албан байгуулагд)	1	III-IV
Б2. СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛ				10	
26	1	...	Дэлхийн урлагийн түүх	2	IV
27	2	...	Хууль, эрх зүй	2	IV
28	3	...	Соёлын менежментийн онол, арга зүй	2	IV
29	4	...	Гадаад хэл (хятад, орос, япон, солонгос гэх мэт)	2	IV
				Нийт багц цаг: 113	

11/ Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO):

- Мэдлэг: Уртын дууны талаарх өргөн ойлголт болон дуулах олон хэлбэр, агуулга бүхий онолын мэдлэгтэй, түүнийгээ ажил мэргэжилдээ ашигладаг уртын дуучин болно.
- Ур чадвар: 1/ Нийгмийн аливаа орчинд өөрийн өвөрмөц дуулах ур чадварыг илэрхийлэн харуулдаг тогтвортой сэтгэл зүйтэй, 2/ амьсгалахуйн аргыг дуу тус бүрд тохируулан тооцоолж хэвшсэн, 3/ хоолойн эрүүл мэндээ сахин хамгаалах өөрийн арга барилаа олсон, 4/ дуулалтын хувийн онцлогоо олж эгшиглэлээ тохируулах замаар насан туршдаа суралцан дуулж хөгжих итгэл үнэмшил, арга барилтай, 5/ хэрэгцээт уртын дуугаа аливаа орчин нөхцөлтэй уялдуулан сонгож, судалгаанд үндэслэн урын сангаа баяжуулан өргөтгөх чадвартай, 6/ бусад угсаатан, үндэстний соёл, урлаг, дуу хөгжмийн мэдлэгээ уран бүтээлдээ хөрвүүлэн ашигладаг орчин үеийн уртын дуучны олон талт ур чадвар эзэмшсэн байх болно.
- Хандлага: 1/ Амьдралын орчин, ажлын орчин, нийгмийн орчин гурвыг адил тэнцүү гамтай хэрэглэгч, 2/ хувийн үнэт зүйл, мэргэжлийн үнэт зүйл, үндэстний үнэт зүйл, улсын үнэт зүйл дөрвийг тэнцүү эрхэмлэсэн бие хүн болж төлөвшсөн уртын дуучин болно.

12/ Ашиглах эх хэрэглэгдэхүүн:

1. Дотоод, гадаадын мэргэжлийн хэвлэмэл ном, сэтгүүл, эмхэтгэл
   Дотоод, гадаадын мэргэжлийн цахим ном, сэтгүүл: www.scholar.google.com, www.researchgate.net, www.jstor.org, www.academia.edu гэх мэт цахим үүр
2. Хөгжим ба Анагаахын салбарын техник, технологи, гарын авлага зэрэг болно.

Дүгнэлт

1. Монгол улс дахь уртын дууны сургалтын нийтлэг нь мэргэжлийн тусгай семинар буюу хоолойн дасгал-арга-ажлын хичээл байдаг. Түүнчлэн, хоолойн 1, эсвэл 2 дасгалыг I-IV курс хүртэлх хугацаанд хэрэглэдэг уламжлал тогтсон. Тэгвэл бидний энэ удаагийн судалгааны үр дүнд 6 болон түүнээс дээш тооны уян хатан буюу уртын дууны олон шугамт аялгуу, дуулах баялаг ур чадварын уламжлалд үндэслэсэн шинэ шинэ дасгал аргуудыг зохион хэрэглэх боломж байна. Жишээ нь, судлагчийн хувьд одоогоор монгол туургатны давхардсан тоогоор 300 гаруй өвлөн уламжлагчийн дуулсан 906 уртын дуу, нийт 30 гаруй төрөл зүйлийн аялгууны зүй тогтолд үндэслэсэн 20 шахам дасгалыг зохион ашиглаж байна. Тэдгээр нь эл өгүүллийн хэлэлцүүлэг хэсэгт туссан зургаан дасгалаас ургуулан авч тухайн суралцагчийн дуулах ур чадварын хөгжлийн явцтай уялдуулдаг "тохиолдох дасгал аргууд" юм. Өөрөөр хэлбэл, суралцагчийн курс ахих тусам судлан дуулдаг сэдэвт дуутай нь холбох замаар хоолойн дасгал аргыг хөгжүүлэн хэрэглэх боломжтой.
2. Үндсэн мэргэжлийн буюу уртын дууны онол, арга зүйн цуврал лекц хичээлийг эхлэх нөөц хуримтлагдаад ихээхэн цаг хугацаа алдагдсан билээ. Тиймээс мэргэжлийн суурь хичээл (CLO)-ийг баяжуулах замаар түүнтэй нягт уялдаа хамаарал бүхий ойролцоогоор найман сэдвийг шинээр нэвтрүүлэх боломж байгаа нь энэ удаагийн судалгааны хэлэлцүүлгээр илэрсэн гэж үзэж болно.
3. Дуут дүрсийн арга энэхүү сургалтын хөтөлбөрийн үр дүнг дэмжих бодит хөшүүргэ болсон гэж дүгнэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, судлагчийн зүгээс монгол уртын дууны сургалтад оруулж буй арга зүйн нэгэн хувь нэмэр нь "Дуут дүрс" (Spectrogram), түүний үйл ажиллагааны "Схем-хувилал" (Зураг 1) болно.

Ашигласан материалын жагсаалт

Байгалмаа, Чүлтэм. 2013. *Багшийн мэргэжлийн хөгжил туршилт судалгаа*. Улаанбаатар: Бит Пресс.

Дорждагва, Мягмарсүрэн. 2018. *Халх монголчуудын уртын дуу, зан үйл-I*. Улаанбаатар: Арвай принтинг.

Дорждагва, Мягмарсүрэн. 2022. *Монгол уртын дууны судалгаа*. Улаанбаатар: Nandir.

Дорждагва, М. "Сургалтын тэмдэглэл." Гар бичмэл. МҮИС. Хичээлийн II байр, 601 тоот; "Айзам" төв. Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль, 105 тоот, 2023-2024.

Жанцанноров, Нацаг. 2005. т.ү. "Давхиулах." *Уртын дууны уламжлалт зарим нэр томьёоны гаргалгаа*. Улаанбаатар.

Жилээ Ж., Тамир Х., Дэлгэржав, М. 2020. *Сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.

Ичинхорлоо, Ш. 2013. *Сургалтын арга зүйн шинэчлэл*. Улаанбаатар: 99973-5-015-4.

Хавсралт. *Хоолойн дасгал ажлын танин мэдэхүйн алхмууд ба үнэлгээний хуудас*
Танин мэдэхүйн алхмууд



Хүснэгт 1. *Үнэлгээний хуудас 1*

Сэдэв	Олж авсан шинэ санаа	Цаашид хэрэгжүүлэх арга зам
Суралцагчийн дуулах мэдлэг, чадвар, хандлагыг оношлох	-Суралцагчийг ядрааж буй хоолойн дасгалыг багасгах!!!, -Урам өгөх шаардлагатай	1/ Тухайн суралцагчийн онцлогт тохирсон хоолойн дасгал зохин хэрэглэх 2/ Өгүүлэхүйн эрхтнийх нь өвөрмөц заяасан тогтолцоог нь ярилцан урам зориг өгөх

Хүснэгт 2. *Үнэлгээний хуудас 2*

a/ Ерөнхий дуулалт	b/ Дотоод үйл явц	c/ Угсаатны уламжлалаас суралцаж буй явц	d/ Хандлага
1/ Хувийн онцлогт нь суурилан хөгжиж буй явцыг оношлох, 2/ Шинэ санаа олох, цаашид хэрэгжүүлэх зүйлсийг жагсаах	1/ Суралцагчийн сэтгэл санаа-эрүүл мэндийн байдал дуу хоолойгоор хэрхэн илэрч буйг ажиглах (*нүүрний булчингийн таталт-тийм, үгүй, чинэрэлт-тийм, үгүй гэх мэт*), 2/ Шинэ санаа олж хэрэгжүүлэх зүйлсийг жагсаах	1/ Өгөгдсөн сэдэвт дууны угсаатны онцлогтой хэл аялга дуудлага бүхий аялгууны хэлбэр, шүлгийн үзэл санаа, утга агуулгыг зөв эзэмшин илэрхийлэх явцыг оношлох, 2/ Шинэ санаа олж цаашид хэрэгжүүлэх зүйлсийг жагсаах	1/ Тайзны хүндэтгэл, хариуцлага, тэсвэр хатуужил, төлөвшлийг дуулах явц, үйл хөдлөлөөс нь оношлох, 2/ Шинэ санаа олж цаашид хэрэгжүүлэх зүйлсийг жагсаах